


ФАКТОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ГЭЖ ЮУ ВЭ?

Байгууллага богино хугацааны хөрвөх чадварын хэрэгцээгээ хангах зорилгоор авлагаа гуравдагч этгээдэд худалдах, уг этгээд нь авлагыг цуглуулж, үүсэх эрсдэлийг бүрэн хариуцах санхүүгийн үйлчилгээний хэлбэр юм.



Факторингийн үйлчилгээний төрлүүд


<p>1 Хариуцах факторинг</p>		<p>Худалдагч байгууллагад бий болох эрсдэлийг өөрөө хариуцана.</p>
<p>2 Үл хариуцах Факторинг</p>		<p>Факторингийн байгууллага худалдагчийн зээлийн эрсдэлийг хариуцна.</p>
<p>3 Хөнгөлөлттэй факторинг</p>		<p>Авлагыг цуглуулах үүргийг худалдагч хариуцдаг тул шимтгэлийн хэмжээ бага.</p>
<p>4 Банкны оролцоотой факторинг</p>		<p>Худалдагчийн бүх авлагыг бүрэн санхүүжүүлнэ.</p>
<p>5 Дотоодын болон хил дамнансан факторинг</p>		<p>Дотоодод болон олон улсад факторингийн үйл ажиллагаа явуулдаг.</p>
<p>6 Олон талт факторинг</p>		<p>Дээрх үйлчилгээнүүдээс 2 болон түүнээс дээш төрлийн үйлчилгээ үзүүлдэг.</p>

Факторингийн үйл ажиллагааны явц

Худалдагч тал нь бараа бүтээгдэхүүнийг худалдан авагчид хүргүүлэх болон төлбөр хийх хугацааг тохирно.

Худалдагч нь худалдан авагчаас бараа, бүтээгдэхүүний үнийг нэхэмжлэх эрхийг факторингийн үйлчилгээ үзүүлэгчид (банк болон зээлийн байгууллага)–д шилжүүлнэ.

Факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь үлдэгдэл төлбөрийг худалдагчид шилжүүлэх ба өөрийн үйлчилгээний шимтгэлийг суутган авна.



Худалдан авагчийн зүгээс бараа, бүтээгдэхүүний үнийг факторингийн үйлчилгээ үзүүлэгчид төлнө.

Факторингийн үйлчилгээ үзүүлэгч нь худалдсан бараа бүтээгдэхүүний үнийн тодорхой хэсгийг (жишээ нь: 70 хүртэл хувь) худалдагчид шилжүүлнэ.

ФАКТОРИНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ

Давуу тал



Дутагдалтай тал

1 Байгууллагын зээлийн эрсдэлийг бууруулдаг.

2 Авлагыг урьдчилан авснаар бизнесийн байгууллагын хөрөнгийн эргэлтийг хурдасгадаг.

3 Үйл ажиллагааны тасралтгүй байдлыг дэмждэг.

1 Факторингийн үйлчилгээ авснаар шимтгэл төлнө.

2 Факторингийн үйлчилгээ авснаар худалдагч болон худалдан авагчийн харилцаанд сөрөг нөлөө үзүүлдэг.

3 Ашиг бууруулдаг